



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Цагаан сарыг угтсан бүх нийтийн  
их цэвэрлэгээний аян зохион  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9.4.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам”-ын 2.4.6, 5.3.2, 5.3.5, 5.3.6, 5.3.7 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам, талбай, орон сууц болон хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Цагаан сарын баярын өдрийг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээний удирдамжийг нэгдүгээр, Аянд зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тус аянд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодыг бүрэн хамруулж ажиллахыг хороодын Засаг дарга нарт, байгууллагын орчны 50 метр газрын цэвэрлэгээг чанар үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй болсон гэр хорооллын гудамж зам талбайн цасыг цэвэрлэж тусгай зориулалтын авто машин чөлөөтэй зорчих нөхцөл бүрдүүлэхийг Багахангай тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа), Илч-Орд ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т үүрэг болгосугай.

4. Аяныг зохион байгуулахад шаардагдах зардал болох 1,089,200 (Нэг сая наян есөн мянга хоёр зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Их цэвэрлэгээний аяныг нэгдсэн удирдлагаар хангаж тайлан мэдээг танилцуулж, ажлаа сурталчилж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200029

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 01 дүгээр сарын 25 ны өдрийн  
А.О.О. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



## ЦАГААН САРЫГ УГТСАН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЯНЫ УДИРДАМЖ

### Нэг.ЗОРИЛГО

1.1.Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, гуу жалга, үерийн далан шуудуунд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил хашаа, талбай, нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг ачиж, тээвэрлэх, халтиргаа гулгааг арилгах зэрэг чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудыг цэвэрлэгээний үйл ажиллагаанд идэвхжүүлэн оролцуулах, иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү удирдамжийн зорилго оршино.

### Хоёр.ЗОРИЛТ

2.1.Цагаан сарыг угтсан их цэвэрлэгээг Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Хороод, бүх төрийн болон хувийн ААНБ, СӨХ-үүд, сургууль цэцэрлэг, Дүүргийн дэргэдэх байгууллага, нэгжүүдийг бүрэн хамруулан зохион байгуулж, бүх нийтийн хөдөлгөөн (субботник) болгож өрнүүлэхэд оршино.

### Гурав.ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

3.1. Хамрах хүрээ: Дүүргийн 1, 2 дугаар хорооны ажлын алба

3.2. Хэрэгжүүлэх хугацаа: 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зохион зохион байгуулна.

3.3. Хамрагдах байгууллага: Цэвэрлэгээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ, орон сууцны контор, сургууль, цэцэрлэг, хог хаягдал, зам цэвэрлэгээний байгууллага, иргэд хамрагдана.

### Дөрөв. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1.Дүүргийн Засаг даргын тамгын газар нь хороодын ажлын албаны цэвэрлэгээний ажлын зохион байгуулалт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Засаг даргын харьяа болон бусад байгууллагуудаас татан оролцуулж болно.

4.2. Цэвэрлэгээний ажлын явц, тайланг ААНБ-ууд 2024 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 16:00 цагийн дотор удирдамжид заагдсан чиглэлийн дагуу ажилласан арга хэмжээний талаарх илтгэх хуудас бичиж /А4 хэмжээтэй 1 хуудас байна/, харьцуулсан фото зургийн хамт ЗДТГ-ын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Батхуяг)-т DOCX форматаар bbatnacag@gmail.com цахим хаягаар илгээнэ.

### Тав. АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах чиглэлээр:

❖ Аж ахуй нэгж, байгууллага, СӨХ, төрийн байгууллагууд, Ерөнхий боловсролын сургууль СӨБ болон худалдаа үйлчилгээний байгууллагын оролцоог хангуулах,

- халтиргаа гулгаа, хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлүүлэх,
- ❖ Гудамж зам талбайд ил задгай хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх
- ❖ Хогийн сав, хогийн бункерүүдын суллалтыг хийх
  - Үерийн хамгаалалтын далан суваг, гуу жалганы ахуйн хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх
  - ТҮК, зам талбайн цэвэрлэгээний байгууллага, ААНБ, СӨХ-ийн оролцоо хандлагыг нэмэгдүүлнэ.
  - Цагаан сарын баярын өдрүүдэд бункерт хогны бөөгнөрөл үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажиллах
- ❖ Гэрэлтүүлгийн засвар арчлалтыг сайжруулах, асалтыг нэмэгдүүлэх. Гэрэлтүүлгийн асалтын хувийг нэмэгдүүлэх, (100%)
- ❖ Шонгийн тагжуулалт, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авах.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны .6.1... дүгээр сарын ...24... ны өдрийн  
А.О.О. дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ  
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Мот/цаг	Цаг	Тоо хэмжээ (летр)	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Шатахуун	17.5	16	280	3890	1,089,200
Нийт үнэ:						<b>1,089,200</b>